



**ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ СТАНДАРТ,
ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР**


БАТЛАВ.
БҮТЭЭГДЭХҮҮН ТОГТОЛЦООНЫ
БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА *[Signature]* В ГАНЗОРИГ

(тамга) (Гарын үсэг)

2023 оны 04 сарын 10 өдөр

ТОХИРЛЫН БОЛОН АЮУЛГҮЙН ТЭМДЭГИЙН
ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ, СУНГАХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ,
ЦУЦЛАХ ЖУРАМ

СХЗГ-07-ББ-01(03):2020



Улаанбаатар хот

| | | | |
|---|---|---------------------------------|-----|
| Баримт бичгийн нэр: | БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ, ХАДГАЛАХ, ХУГАЦАА СУНГАХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ЦУЦЛАХ ЖУРАМ | | |
| Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар: | СХЗГ-07-ББ-01(03):2023 | | |
| Баталсан огноо: | 2020.03.02 | Баримт бичгийн хувилбар: | III |

Агуулга

| № | Гарчиг | Хуудасны дугаар |
|----|-------------------------------------|-----------------|
| 1 | Зорилго | 3 |
| 2 | Хамрах хүрээ | 3 |
| 3 | Норматив эшлэл | 3 |
| 4 | Нэр томъёо, тодорхойлолт | 3 |
| 5 | Баталгаажуулалтын гэрчилгээ олгох | 3 |
| 6 | Магадлах хяналт | 4 |
| 7 | Гэрчилгээний хугацааг сунгах | 4 |
| 8 | Гэрчилгээг түдгэлзүүлэх | 4 |
| 9 | Гэрчилгээг цуцлах | 5 |
| 10 | Баталгаажуулалтын шийдвэр, мэдээлэл | 5 |

Хэвлэгдсэн хувь нь хуулбар хувь болохыг анхаарна уу.
Шаардлагатай тохиолдолд эх хувьтай тулган үзнэ үү.

| | | | |
|---|---|---------------------------------|-----|
| Баримт бичгийн нэр: | БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ, ХАДГАЛАХ, ХУГАЦАА СУНГАХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ЦУЦЛАХ ЖУРАМ | | |
| Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар: | СХЗГ-07-ББ-01(03):2023 | | |
| Баталсан огноо: | 2020.03.02 | Баримт бичгийн хувилбар: | III |

1. Зорилго

Энэхүү журам нь Стандарт, хэмжил зүйн газрын Бүтээгдэхүүн, тогтолцоо баталгаажуулалтын газар, түүний харъяа баталгаажуулалтын байгууллагаас баталгаажуулалтыг олгох, хадгалах, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, цуцлах үйл ажиллагааг зохицуулна.

2. Хамрах хүрээ

Баталгаажуулалтын байгууллагаас тохирлын үнэлгээний үр дүн, дүгнэлтийг үнэлж цэгнэн, бусад мэдээлэлд үндэслэн баталгаажуулалтын шийдвэр гаргах үйл ажиллагаанд хамаарна.

3. Эрх зүйн үндэслэл

- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль /13.2, 13.3, 13.4/

- Монгол Улсын Засгийн Газрын Тогтоол 2018 оны 10-р сарын 03-ны өдрийн дугаар 291

4. Норматив эшлэл

- Тохирлын үнэлгээ – Баталгаажуулалт явуулдаг байгууллагад тавих шаардлага MNS ISO/IEC 17065:2013;
- Тохирлын Үнэлгээ, Бүтээгдэхүүн баталгаажуулалтын үндсэн асуудал ба бүтээгдэхүүн баталгаажуулалтын схемийн заавар MNS ISO/IEC 17067:2014;

Хугацаагүй эш таталтын хувьд эш татагдсан норматив баримт бичгийн хамгийн сүүлчийн хэвлэлийг хэрэглэнэ

5. Нэр томъёо, тодорхойлолт

“**Тохирлын гэрчилгээ**” - Тодорхой стандарт буюу бусад техникийн нөхцөлд тохирч байгаа бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээг гэрчлэн гуравдагч этгээдийн баталгаажуулалтын тогтолцооны журмын дагуу үйлдэж буй баримт бичиг ;

“**Аюулгүйн тэмдэг**” - бүтээглэхүүн нь техникийн зохицуулалтаар тогтоосон гаардлагыг бүрэн хангаж байгааг тодорхойлсон тэмдэглэгээг;

“**Баталгаажуулалтын схем**” – нэг ижил тогтоосон шаардлагад нийцснийг хөндлөнгөөс гэрчлэх

“**Бүтээгдэхүүн**”- үйлдвэрлэл, үйлчилгээний үйл явцад бий болсон үр дүнг

“**Баталгаажуулалтын байгууллага**” - Баталгаажуулалтын схемийг хэрэгжүүлэгч эрх бүхий тохирлын үнэлгээний байгууллага .

6. Баталгаажуулалтын гэрчилгээ олгох

6.1 Баталгаажуулалтын байгууллагын дэргэдэх орон тооны бус Баталгаажуулалтын зөвлөл нь бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцад явуулсан үнэлгээ, дүгнэлтийг хэлэлцэж гэрчилгээ, тэмдэг олгох, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, цуцлах шийдвэрийг гаргах ба баталгаажуулалтын байгууллага нь үйлчлүүлэгчид мэдэгдэнэ.

6.2 Тухайн бүтээгдэхүүний норматив техникийн баримт бичгийн хүчинтэй хугацаа, дүгнэлт, үнэлгээний үр дүн тайлан болон бусад мэдээлэл (олон нийтийн мэдээлэл, үнэлгээний тайлангийн талаар үйлчлүүлэгчээс гаргасан санал) зэргийг харгалзан дараах байдлаар гэрчилгээг гурав хүртэл жилийн хугацаагаар олгоно

Хэвлэгдсэн хувь нь хуулбар хувь болохыг анхаарна уу.
Шаардлагатай тохиолдолд эх хувьтай тулган үзнэ үү.

| | | | |
|------------------------------------|---|--------------------------|-----|
| Баримт бичгийн нэр: | БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ, ХАДГАЛАХ, ХУГАЦАА СУНГАХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ЦУЦЛАХ ЖУРАМ | | |
| Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар: | СХЗГ-07-ББ-01(03):2023 | | |
| Баталсан огноо: | 2020.03.02 | Баримт бичгийн хувилбар: | III |

- Дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүнд гэрчилгээг олгох

- а. Анх удаа тохирлын үнэлгээнд хамрагдсан бүтээгдэхүүн, үйлчилгээнд гэрчилгээг 1 жилээр,
- б. Хоёр ба түүнээс дээш удаа сунгуулж байгаа тохиолдолд гэрчилгээг 1- 3 хүртэл жилээр,
- в. Үндэсний стандартгүй бүртгүүлэн хэрэглэх гадаад улсын дэвшилтэт стандарттай бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээг бүртгэлийн хугацаатай уялдуулан олгоно. Энэ хугацаанд Үндэсний стандартаар батлуулаагүй бол тохирлын гэрчилгээг сунгахгүй.

- Импортын бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээг олгох

- а.ЗГ- ын 291 тогтоолын 2.4 зааснаар жагсаалтад заасан согтуулуулах ундаа, тамхины төрлийн импортын бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтхүүлэхийн өмнө тухайн бүтээгдэхүүн.загварын тохирлын үнэлгээнд заавал хамруулна.
- б.ЗГ-ын 2.4т заагдаагүй бусад бүтээгдэхүүнд загварын баталгаажуулалтын тохирлын гэрчилгээ олгохгүй.
- в. “ Загварын баталгаажуулалт” -ын гэрчилгээг 6 сарын хугацаатай олгоно.
- г. Импортын тохирлын гэрчилгээнд бүтээгдэхүүний тоо хэмжээг тавьж 1 жилийн хугацаатай олгоно.

6.3 Баталгаажуулалтын зөвлөлөөс гаргасан шийдвэрийг үндэслэн дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хувьд асуудлыг хариуцаж шийдвэрлүүлсэн баталгаажуулалтын шинжээч гэрчилгээг бичиж олгоно.

6.4 Гэрчилгээг E-сертификейшн программаар бичих бөгөөд бүртгэлийн дугаартай байна.

6.5 Баталгаажуулалтын газраас олгох гэрчилгээний загвар нь Стандарт, хэмжил зүйн газрын “Гэрчилгээ, тооцоот баримтыг хэрэглэх, түүнтэй холбоотой харилцааг зохицуулах журам”-ын Хэрэглэн баталгаатай байна

6.6 Гэрчилгээ, тэмдэглэгээг эзэмшүүлэхтэй холбогдуулан үйлчлүүлэгчтэй гэрээ байгуулна.

7 Магадлах хяналт

7.1 Баталгаажуулалтын байгууллага нь гэрчилгээний хүчинтэй үйлчлэх хугацаанд баталгаажуулсан бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явц, менежментийн тогтолцоо нь холбогдох шаардлагуудад үргэлжлэн нийцэж байгаа эсэхийг тогтоох зорилгоор магадлах хяналтыг гэрээний дагуу явуулна.

7.2 Хэрэглэгчийн санал гомдлын мөрөөр магадлах хяналтыг явуулж болно.

7.3 Магадлах хяналтын дүнгээр баталгаажуулалтын хүрээг өргөтгөх, багасгах, тохирлын гэрчилгээ хэрэглэх гэрээг түдгэлзүүлэх, хүчингүй болгож болно.

8 Гэрчилгээний хугацааг сунгах

8.1 Гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээний хүчинтэй хугацааг дуусахаас 60 хоногийн өмнө сунгуулах хүсэлтийг Баталгаажуулалтын байгууллагад гаргана.

8.2 Хүсэлтийг үндэслэн Монгол Улсад бүтээгдэхүүн, үйлчилгээг баталгаажуулалтын схемийн дагуу явуулах нийтлэг журмын дагуу тохирлын үнэлгээг явуулна.

9 Гэрчилгээг түдгэлзүүлэх

9.1 Дараах тохиолдолд гэрчилгээ эзэмшүүлэгч буюу Баталгаажуулалтын байгууллага нь гэрчилгээ эзэмшигчийн гэрчилгээ, хэрэглэх эрхийг албан бичгээр түр хугацаагаар зогсоож, зөрчил, доголдлыг нь арилгуулах арга хэмжээг авахуулна. Үүнд:

Хэвлэгдсэн хувь нь хуулбар хувь болохыг анхаарна уу.
Шаардлагатай тохиолдолд эх хувьтай тулган үзнэ үү.

| | | | |
|---|---|---------------------------------|-----|
| Баримт бичгийн нэр: | БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ, ХАДГАЛАХ, ХУГАЦАА СУНГАХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ЦУЦЛАХ ЖУРАМ | | |
| Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар: | СХЗГ-07-ББ-01(03):2023 | | |
| Баталсан огноо: | 2020.03.02 | Баримт бичгийн хувилбар: | III |

- а) гэрчилгээ эзэмшигчийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ, үйл ажиллагаанд холбогдох стандартын шаардлага хангахгүй тохиолдол илэрсэн;
- б) гэрчилгээ эзэмшигч нь энэ гэрээнд заасан үүргээ биелүүлэхгүй байгаа байдал илэрсэн;
- в) бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанарын талаар хэрэглэгч, худалдан авагчаас үндэслэл бүхий гомдол гарсан
- г) гэрчилгээ эзэмшигч нь гэрээнд заасан үйлчилгээний үнэ, зардлыг төлөхөөс татгалзах;
- д) гэрчилгээ эзэмшигч гэрчилгээ, стандартын тэмдэглэгээ хэрэглэхтэй холбогдсон дүрэм, журмуудыг зөрчсөн;
- е) магадлах хяналт явуулахаас 2 ба түүнээс дээш удаа татгалзах;
- ж) давтан баталгаажуулалтыг явуулахаас татгалзах.
- з) баталгаажуулсан үйлчлүүлэгч сайн дураараа түдгэлзэх хүсэлт тавьсан.

9.2 Гэрчилгээг түдгэлзүүлэх хугацаа нь 3 сараас хэтрэхгүй байна.

9.3 Гэрчилгээг түдгэлзүүлснээр, үйлчлүүлэгчийн баталгаажуулалт нь түр хугацаагаар хүчингүй байна.

9.4 Түдгэлзүүлсэн үед үйлчлүүлэгч нь баталгаажуулалтыг цаашдын сурталчилгаандаа хэвээр хадгалбал баталгаажуулалтын газраас албан мэдэгдэл хүргүүлнэ.

9.5 Баталгаажуулалтын байгууллага нь баталгаажуулалтын шийдвэрийн үйл явц, баталгаажуулалт олгосон мэдээллийг www.masm.gov.mn, www.establishment.gov.mn цахим хуудсаар, түдгэлзүүлсэн буюу хүчингүй болгосон тухай мэдээллийг Баталгаажуулалтын байгууллагын мэдээллийн самбараар хүргэнэ.

9.6 Баталгаажуулалтын байгууллагаас гэрчилгээ, хэржлжх гэрээг түдгэлзүүлсэн үед гэрчилгээ эзэмшигч нь холбогдох зөрчил, доголдлыг арилгаагүй бол баталгаажуулалтын хүрээг багасгах эсвэл цуцлах асуудлыг баталгаажуулалтын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ.

9.7 Баталгаажуулагдсан үйлчлүүлэгчийн баталгаажуулалтын хамрах хүрээний нэг хэсэг баталгаажуулалтын шаардлагыг байнга буюу ноцтой зөрчиж байгаа тохиолдолд энэ асуудлыг баталгаажуулалтын зөвлөлийн хуралд оруулж шаардлага хангахгүй байгаа хамрах хүрээг багасгах шийдвэрийг гаргаж болно.

9.8 Баталгаажуулалтын байгууллага нь баталгаажуулагдсан үйлчлүүлэгчийн баталгаажуулалтыг түдгэлзүүлэх, цуцлах, хамрах хүрээг багасгах талаар бодит нотолгоонд үндэслэн зөв шийдвэрийг гаргана.

9.9 Баталгаажуулалтын байгууллага нь баталгаажуулагдсан үйлчлүүлэгчийн баталгаажуулалтыг түдгэлзүүлсэн, баталгаажуулалтын хамрах хүрээг багасгасан, цуцалсан тохиолдолд үйлчлүүлэгчид баталгаажуулалтын зөвлөлийн шийдвэрийн талаар болон хэрэглэгчдийг төөрөгдөлд оруулахаар сурталчилгаа хийхийг хориглох тухай мэдээлнэ.

10. Гэрчилгээг цуцлах

Дараах тохиолдолд гэрчилгээг цуцална. Үүнд:

- а) илэрсэн зөрчил нь бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанарт ноцтой нөлөөлөхөөр байх;
- б) гэрээний нөхцлийг зөрчсөн;
- в) зөвшөөрлийн хугацааг түдгэлзүүлсэн түр зогсоосон үед гэрчилгээ эзэмшигч нь тодорхой арга хэмжээ аваагүй;
- г) гэрчилгээ эзэмшигч аж ахуйн нэгж татан буугдсан буюу тухайн бүтээгдэхүүнийг Хэвлэгдсэн хувь нь хуулбар хувь болохыг анхаарна уу. Шаардлагатай тохиолдолд эх хувьтай тулган үзнэ үү.

| | | | |
|---|---|---------------------------------|-----|
| Баримт бичгийн нэр: | БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ, ХАДГАЛАХ, ХУГАЦАА СУНГАХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ЦУЦЛАХ ЖУРАМ | | |
| Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар: | СХЗГ-07-ББ-01(03):2023 | | |
| Баталсан огноо: | 2020.03.02 | Баримт бичгийн хувилбар: | III |

үйлдвэрлэх, ажил үйлчилгээ эрхлэхээ больсон;

д) гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээг хэрэглэх эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулаагүй;

е) гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээг бусдад дур мэдэн шилжүүлсэн

10 Баталгаажуулалтын шийдвэрийг мэдээлэх

Баталгаажуулалтын байгууллага нь гэрчилгээтэй бүтээгдэхүүн үйлчилгээний талаар баталгаажуулалтын мэдээллийн нэгдсэн санд байршуулж, нийтэд мэдээлнэ.

| | | | |
|------------------------------------|---|--------------------------|-----|
| Баримт бичгийн нэр: | БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ, ХАДГАЛАХ, ХУГАЦАА СУНГАХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ЦУЦЛАХ ЖУРАМ | | |
| Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар: | СХЗГ-07-ББ-01(03):2023 | | |
| Баталсан огноо: | 2020.03.02 | Баримт бичгийн хувилбар: | III |

СХЗГ-07-ББ-01(03):2020 Маягт 01

Экспортын гэрчилгээ хүлээж авсан бүртгэл он

| Д/Д | Үнэт цаасны дугаар | Хүлээлгэн өгсөн /НЭР/ | Хүлээлгэн өгсөн /Гарын үсэг/ | Хүлээн авсан /НЭР/ | Хүлээн авсан /Гарын үсэг/ |
|-----|--------------------|-----------------------|------------------------------|--------------------|---------------------------|
| 1 | | | | | |
| 2 | | | | | |
| 3 | | | | | |
| 4 | | | | | |
| 5 | | | | | |
| 6 | | | | | |
| 7 | | | | | |
| 8 | | | | | |
| 9 | | | | | |
| 10 | | | | | |

СХЗГ-07-ББ-01(03):2023 Маягт 02

Импортын гэрчилгээ хүлээж авсан бүртгэл он

| № | Импорт | Аж ахуй нэгжийн нэр | ш | хос | Санхүүгийн дугаар | Он сар өдөр | Шинжээчийн нэр | Гарын үсэг | Бүтээгдэхүүний нэр |
|---|--------|---------------------|---|-----|-------------------|-------------|----------------|------------|--------------------|
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |

СХЗГ-07-ББ-01(03):2023 Маягт 03

Дотоодын гэрчилгээ хүлээж авсан бүртгэл он

| № | Дотоод | Аж ахуй нэгжийн нэр | ш | хос | Санхүүгийн дугаар | Он сар өдөр | Шинжээчийн нэр | Гарын үсэг | Бүтээгдэхүүний нэр |
|---|--------|---------------------|---|-----|-------------------|-------------|----------------|------------|--------------------|
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |

Хэвлэгдсэн хувь нь хуулбар хувь болохыг анхаарна уу.
Шаардлагатай тохиолдолд эх хувьтай тулган үзнэ үү.

Дотоодын бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалтын
материал хүлээн авсан бүртгэл

| Д/Д | Бүрдүүлж өгөх материалын дараалал | Байгаа эсэх | Өгсөн хугацаа | Хүлээлгэн өгсөн гарын үсэг |
|-----|---|-------------|---------------|----------------------------|
| 1. | Гэрээ | | | |
| 2. | Олгосон тохирлын гэрчилгээ | | | |
| 3. | Мөнгөний баримт наах | | | |
| 4. | Хуралд оруулсан тайлан | | | |
| 5. | Үнэлгээний хуудас | | | |
| 6. | Удирдамж | | | |
| 7. | ААНБ-аас ирсэн албан бичиг | | | |
| 8. | Холбоо барьсан тэмдэглэл | | | |
| 9. | ААНБ-ын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар | | | |
| 10. | Бусад материал цэгцэлж өгөх | | | |

ЖИЧ: Бүх материалын үдээсийг нь авч өгөх

Хүлээн авсан